БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2024/181/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2024 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@ audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: Р.Баярмаа<br>Утас: 99265539 Цахим хаяг: bayarmaar@ audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 2
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 4
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 10
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 13
**4.1 Ерөнхий зүйл** ........ 13
**4.2 Материаллаг байдал** ........ 14
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 14
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** 14
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 14
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 14
**4.5.1 Завсрын аудитын талаар** ........ 14
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 15
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 15
**5.1 Төлбөрийн акт** ........ 15
Төлбөрийн акт тогтоогдоогүй. ........ 15
**5.2 Албан шаардлага** ........ 15
**5.3 Зөвлөмж** ........ 15
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2024.02.21 № 155

танай ____________ -ны № ____________ -т

БУЯНТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА А.ЕЛЖАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

**Аудитын гол асуудал**

Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402241

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **111466413.68** | **169749520.74** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 19663769.00 | 68363548.22 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 19663769.00 | 68363548.22 |
| **3121** | **Төгрөг** | 19663769.00 | 68363548.22 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 19663769.00 | 68363548.22 |
| **33** | **АВЛАГА** | 0.00 | 7130880.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 0.00 | 7130880.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 91802644.68 | 94255092.52 |
| **351** | **Түүхий эд материал** | 81251920.90 | 76911792.24 |
| 35130 | Эм боох материал | 81251920.90 | 76911792.24 |
| **354** | **Хангамжийн материал** | 10550723.78 | 17343300.28 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 62000.00 | 188000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 739685.00 | 8982729.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 0.00 | 1266000.00 |
| 35460 | Хүнсний материал | 9749038.78 | 6906571.28 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **396333067.51** | **392897012.65** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 396333067.51 | 392897012.65 |
| **392** | **Биет хөрөнгө** | 391301067.51 | 387865012.65 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 352772600.00 | 352772600.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -44492063.72 | -51948424.52 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 61581077.00 | 47759997.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -28040523.08 | -22378609.08 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 128908313.33 | 157164418.33 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -84929984.40 | -99812638.14 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 37849880.64 | 29429382.20 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -32348232.26 | -25121713.14 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 128000.00 | 0.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -128000.00 | 0.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 5032000.00 | 5032000.00 |
| 39301 | Програм хангамж | 550000.00 | 550000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -550000.00 | -550000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5032000.00 | 5032000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | 0.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **507799481.19** | **562646533.39** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **0.00** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **507799481.19** | **562646533.39** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 507799481.19 | 562646533.39 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 263882593.00 | 263882593.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 263882593.00 | 263882593.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 161739835.31 | 217021433.51 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 161739835.31 | 162174381.31 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 54847052.20 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 82177052.88 | 81742506.88 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **507799481.19** | **562646533.39** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** **Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **640,488,732.15** | **741,104,891.22** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **84,612,442.15** | **42,590,736.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 84,612,442.15 | 42,590,736.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 84,612,442.15 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 84,612,442.15 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | - | 32,942,872.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | - | 9,647,864.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **555,876,290.00** | **698,514,155.22** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 280,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 280,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 28,799,000.00 | 38,680,305.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 28,799,000.00 | 38,680,305.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 526,797,290.00 | 659,833,850.22 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 526,797,290.00 | 659,833,850.22 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **598,410,868.71** | **686,257,839.02** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **595,932,832.69** | **686,257,839.02** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 595,932,832.69 | 686,257,839.02 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 330,775,350.00 | 441,995,252.00 |
| 210101 | Үндсэн цалин | 224,936,146.00 | 288,748,527.00 |
| 210102 | Нэмэгдэл | 79,900,249.00 | 111,082,799.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,101,000.00 | 5,378,000.00 |
| 210104 | Урамшуулал | 20,837,955.00 | 36,785,926.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,348,300.00 | 56,924,344.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,265,300.00 | 39,187,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,270,700.00 | 4,610,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,616,600.00 | 3,688,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 654,100.00 | 922,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,541,600.00 | 8,516,544.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,245,699.31 | 36,126,005.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,008,200.00 | 1,270,205.00 |
| 210302 | Түлш, халаалт | 24,237,499.31 | 34,855,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 65,399,188.00 | 43,663,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,732,888.00 | 2,619,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 49,080,390.00 | 34,409,170.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,875,660.00 | 2,455,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,295,500.00 | 970,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,414,750.00 | 3,210,030.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 59,275,121.66 | 54,828,961.16 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 43,918,195.00 | 47,052,093.66 |
| 210502 | Хоол, хүнс | 4,732,226.66 | 7,476,867.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,624,700.00 | 300,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,576,588.00 | 3,679,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,566,188.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 4,010,400.00 | 3,679,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 754,000.00 | 1,645,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 754,000.00 | 1,645,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 486,170.00 | 2,344,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 354,450.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 17,800.00 | 17,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 44,600.00 | 44,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 19,000.00 | 19,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,070,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 50,320.00 | 67,400.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | - | 1,125,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 63,072,415.72 | 45,050,776.86 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,399,000.00 | 5,681,850.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 59,673,415.72 | 39,368,926.86 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,478,036.02** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,478,036.02 | - |
| 225101 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/ | 2,478,036.02 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **42,077,863.44** | **54,847,052.20** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **42,077,863.44** | **54,847,052.20** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** **Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **598198790.00** | **691383275.22** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **598198790.00** | **691383275.22** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 280000.00 | 0.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 280000.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 28799000.00 | 38680305.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 28799000.00 | 38680305.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 569119790.00 | 652702970.22 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 569119790.00 | 652702970.22 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **574885021.00** | **639693496.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **574885021.00** | **639693496.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **574885021.00** | **639693496.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 330775350.00 | 441995252.00 |
| 210101 | Үндсэн цалин | 224936146.00 | 288748527.00 |
| 210102 | Нэмэгдэл | 79900249.00 | 111082799.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5101000.00 | 5378000.00 |
| 210104 | Урамшуулал | 20837955.00 | 36785926.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43348300.00 | 56924344.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30265300.00 | 39187300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3270700.00 | 4610300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2616600.00 | 3688200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 654100.00 | 922000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6541600.00 | 8516544.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25867000.00 | 36126005.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2008200.00 | 1270205.00 |
| 210302 | Түлш, халаалт | 23858800.00 | 34855800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 64313830.00 | 45058900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5249600.00 | 2748200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 50478320.00 | 34409170.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1875660.00 | 2455500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2295500.00 | 970000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4414750.00 | 4476030.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 99364783.00 | 46238545.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 79927483.00 | 40479145.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8812600.00 | 4634400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10624700.00 | 1125000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6576588.00 | 3679300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2566188.00 | |
| 210604 | Урсгал засвар | 4010400.00 | 3679300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 754000.00 | 1645000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 754000.00 | 1645000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 486170.00 | 2344300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 354450.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 17800.00 | 17800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 44600.00 | 44600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 19000.00 | 19000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 1070500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 50320.00 | 67400.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | 1125000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3399000.00 | 5681850.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3399000.00 | 5681850.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **23313769.00** | **51689779.22** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **3650000.00** | **2990000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3650000.00** | **2990000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 3650000.00 | 2990000.00 |
| 225102 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/ | 3650000.00 | 2990000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-3650000.00** | **-2990000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **0.00** | **0.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 19663769.00 | 48699779.22 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 19663769.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 19663769.00 | 68363548.22 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** **Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 263,882,593.00 | 82,177,052.88 | 161,739,835.31 | | 507,799,481.19 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **263,882,593.00** | **82,177,052.88** | **161,739,835.31** | **0.00** | 507,799,481.19 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | 0.00 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **263,882,593.00** | **82,177,052.88** | **161,739,835.31** | **0.00** | 507,799,481.19 |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **263,882,593.00** | **82,177,052.88** | **161,739,835.31** | **0.00** | 507,799,481.19 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 434,546.00 | | 434,546.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **263,882,593.00** | **82,177,052.88** | **162,174,381.31** | **0.00** | 508,234,027.19 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | -434,546.00 | | | -434,546.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 54,847,052.20 | | 54,847,052.20 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **263,882,593.00** | **81,742,506.88** | **217,021,433.51** | **0.00** | 562,646,533.39 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** **Төгрөгөөр**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 691616700.00 | 604003191.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 691616700.00 | 604003191.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 691616700.00 | 604003191.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 508597400.00 | 441995252.00 |
| 210101 | Үндсэн цалин | 313550800.00 | 288748527.00 |
| 210102 | Нэмэгдэл | 141403900.00 | 111082799.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7018000.00 | 5378000.00 |
| 210104 | Урамшуулал | 46624700.00 | 36785926.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 63681900.00 | 56924344.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43303900.00 | 39187300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5094900.00 | 4610300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4075500.00 | 3688200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1018900.00 | 922000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10188700.00 | 8516544.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 48615700.00 | 46108900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2750000.00 | 2748200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35968100.00 | 34409170.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2478000.00 | 2455500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1892800.00 | 970000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5526800.00 | 5526030.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 55917200.00 | 46238545.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 48456800.00 | 40479145.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6335400.00 | 4634400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1125000.00 | 1125000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1125000.00 | 1125000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1125000.00 | 1125000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1738500.00 | 1645000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1738500.00 | 1645000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2451300.00 | 2344300.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 17800.00 | 17800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 44600.00 | 44600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 19000.00 | 19000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1177500.00 | 1070500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 67400.00 | 67400.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1125000.00 | 1125000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9489700.00 | 7621850.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9489700.00 | 7621850.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 691616769.00 | 672366739.22 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 671953000.00 | 652702970.22 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 671953000.00 | 652702970.22 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 19663769.00 | 19663769.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 19663769.00 | 19663769.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 19663769.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 68363548.22 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 29.00 | 27.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 23.00 | 21.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **29.0** | **27.0** |

| | | | |
|---|---|---|---|
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 24.00 | 22.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 5.00 | 5.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан** **Төгрөгөөр**

Тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Буянт сумын Эрүүл мэндийн төв нь сумын ард иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм. Тайлант онд "Олон улсын эмнэлгийн стандарт, шалгууруудыг хэрэгжүүлж үйлчлүүлэгчдэд чанартай эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлнэ” гэсэн зорилго дэвшүүлж ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Буянт сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд тайлант онд бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Буянт сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг баталж үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 134.9 сая төгрөгөөр буюу 9 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 19,663.77 | 68,363.55 | 48,699.78 |
| Авлага | 0.00 | 7,130.88 | 7130.88 |
| Урьдчилгаа | 0.00 | 0.00 | 0.00 |
| Бараа материал | 91,802.64 | 94,255.09 | 2,452.45 |
| Үндсэн хөрөнгө | 396,333.07 | 392,897.01 | -3,436.05 |
| **Нийт хөрөнгө** | **507,799.48** | **562,646.53** | **54,847.05** |
| Өр төлбөр | 0.00 | 0.00 | 0.00 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 507,799.48 | 562,646.53 | 54,847.05 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **507,799.48** | **562,646.53** | **54,847.05** |

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст 68.4 сая төгрөг болж оны эхнээс 48.7 сая төгрөгөөр өссөн байна.

Авлага данс оны эхэнд үлдэгдэлгүй ба Эрүүл мэндийн даатгалаас дутуу авсан 7.1 сая төгрөгийн санхүүжилтийн авлагыг бүртгэж тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 94.3 сая төгрөг болж оны эхнээс 2.5 сая төгрөгөөр өссөн байна. Эм боох материалын үлдэгдэл 76.9 сая, аж ахуйн материал 9.0 сая, хүнсний материалын үлдэгдэл 6.9 сая төгрөг, бичиг хэргийн материал 0.2 сая төгрөг байна. Төсвийн хөрөнгөөр 126.7 сая төгрөгийн материал худалдан авч, үнэ төлбөргүй 9.6 сая төгрөгийн бараа материал авсан байна. Аймгийн Эрүүл мэндийн газраас 2022 оны жилийн эцэст 24.8 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг үнэгүй хүлээн авч орлогод авсан ба тухайн материал

эм, эмнэлгийн хэрэгслүүд нь ашиглагдахгүй, хугацаа дуусаж байгаа тул тайлант онд зарцуулагдаагүй үлдэгдэлд байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 392.9 сая төгрөг болж 3.4 сая төгрөгөөр буурсан байна. Төсвийн хөрөнгөөр 3.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй 32.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна. ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 17.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, ЭМГ-аас 14.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авсан ба өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу 0.6 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжийг орлогод авч бүртгэсэн байна.

Тайлант онд аймгийн ИТХ-ын тогтоолоор нийт 30.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 54.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 54.8 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны анх батлагдсан төсөв 777.3 сая төгрөг байна. Үүнд: Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 736.8 сая, орон нутгийн төсвөөс 40.5 сая, нийт 777.3 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 65.4 сая төгрөгөөр бууруулж 711.9 сая төгрөгөөр тодотгож баталсан байна

Анх батлагдсан төсвөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 66.6 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 6.7 сая, хангамж, бараа материалын зардлыг 2.5 сая, нормативт зардлыг 9.7 сая, эд хогшил, урсгал засварыг 0.4 сая, томилолтын зардлыг 0.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 0.1 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 1.9 сая төгрөгөөр бууруулж, нийт 65.4 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 659.8 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 40.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлж, 19.7 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулахаар байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 652.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 38.6 сая төгрөгийн санхүүжилт авч, оны эхний үлдэгдлээс 19.7 сая төгрөгийг зарцуулж, нийт 642.6 сая төгрөгийн төсвөөр үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 642.6 сая төгрөг буюу 87.8 хувьтай байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөвлөснөөс 7.1 сая, орон нутгийн төсвөөс 1.8 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсантай холбоотой. Эрүүл мэндийн даатгалын сангаас авсан санхүүжилтээс 68.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Эмнэлгийн тусламж үйлчилгээ | | | | |
| 1 | Нэг иргэнд ногдох нормативаар | 520.9 | 461.9 | -59.0 | 88.7% |
| 2 | Үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ | 150.9 | 122.4 | -28.5 | 81.1% |
| 3 | Дээд шатны төсвөөс хуваарилсан | 19.7 | 19.7 | 0.0 | 100% |
| 4 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 40.5 | 38.6 | -1.8 | 95.3% |
| | **Дүн** | **732.0** | **642.6** | **-89.3** | **87.8** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн төв  нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Буянт сумын Эрүүл мэндийн төв  2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Буянт сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 126.7 сая төгрөгийн материал, 3.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын  газрын аудитор Р.Баярмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Буянт Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 594.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 5.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шалгахаар төлөвлөсөн 33 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлж, хэрэгжилтийг шалгахад алдаа зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсөв өмч, хөрөнгө зарцуулах 27.7 сая төгрөгийн 16 шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 75 хувьтай байна. Өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийтдээ 11.2 сая төгрөгийн зөрчил илэрч 1.9 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 9.3 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгсөн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | 1946.0 | 2 | 1946.0 | 100% |
| Албан шаардлага | 3 | 9278.0 | 3 | 9278.0 | 100% |
| Зөвлөмж | 0 | 0.0 | 0 | 0.0 | |
| **Нийт дүн** | **5** | **11224.0** | **5** | **11224.0** | 100% |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулаг хийгдээгүй. Аудитаар нийтдээ 34.8 сая төгрөгийн зөрчил[1] илэрч 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

Төсөв өмч, хөрөнгө зарцуулах 27.7 сая төгрөгийн 16 шийдвэр, Эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу авсан 7.1 сая төгрөгийн авлагын мэдээллийг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 75 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "...... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд мэдээлээгүй Төсөв өмч, хөрөнгө зарцуулах 27.7 сая төгрөгийн 16 шийдвэр, эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу авсан 7.1 сая төгрөгийн авлагын мэдээллийг нөхөж байршуулан зөрчлийг арилгах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу зөвлөмжийг хүлээн авснаас 30 хоногийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах авлага үүсгэсэн 34.8 сая төгрөгийн 17 шийдвэрийг байршуулаагүй | 1 | 34,855.4 | | | | | 1 | 34,855.4 |
| Дүн | 1 | 34,855.4 | | | | | **1** | 34,855.4 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | 1 | 34,855.4 |